



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

┌ Зочид буудал, дэн буудал, амралтын ┐  
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл  
олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Нарантуул шилтгээн ХХК-ний “Нарантуул” зочид буудлын 17/016, Одод ХХК-ний “Вояж” зочид буудлын 16/138, Дизайнер Клуб ХХК-ний “Спрингс” зочид буудлын 16/104, Ханбэлчир ХХК-ний “Зайсан” зочид буудлын 15/102, Юү Эс Эй Энд Би ХХК-ний “Оргил” зочид буудлын 14/89, Сэлбэ плаза ХХК-ний “УБ сити” зочид буудлын 14/028, Сан хорго ХХК-ний “Сан” зочид буудлын 16/153, Премиум палас ХХК-ний “Премиум” зочид буудлын 16/154, Кореана тайм ХХК-ний “Нийслэл” зочид буудлын 16/099 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

3. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

1150500008

4. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Амар/-д үүрэг болгосугай.

ДАРГА *D. Batm* Д.БАТСҮХ



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2018 оны 01 сарын 16 өдрийн Мэдугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2018.01.16

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Нарантуул шилтгээн ХХК	5010675	Нарантуул	ЧД-ийн 2-р хороо баруун 4 зам
2	Одод ХХК	2066505	Вояж	СБД-ийн 3-р хороо Чингисийн өргөн чөлөө 21
3	Дизайнер Клуб ХХК	2615169	Спрингс	СБД-ийн 1-р хороо Олимпын гудамж 2А
4	Ханбэлчир ХХК	2576201	Зайсан	ХУД-ийн 11-р хороо дайчдын 1-17 тоот
5	ЮУ ЭС ЭЙ ЭНД БИ ХХК	5091543	Оргил	ХУД-ийн 11-р хороо дайчдын 1-10 тоот
6	Сэлбэ Плаза ХХК	2745461	УБ сити	СБД-ийн 7-р хороо эрхүүгийн гудамж
7	Сан хорго ХХК	2856417	Сан	ЧД-ийн Их тойруу 47-р байр
8	Премиум Палас ХХК	5933463	Премиум	ЧД-ийн 5-р хороо тасганы овоо 15150
9	Кореана тайм ХХК	2877031	Нийслэл	БГД-ийн 5-р хороо 10-р хороолол ЭТӨЧ 100 тоот

--ооОоо--